



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 24 өдөр

Дугаар 1/319

Алтай хот

Электрон тамхи, түүний дагалдах
хэрэгслийг худалдан борлуулахыг
хориглох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Тамхины хяналтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7.7 дахь заалт, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй худалдаа үйлчилгээний байгууллага, аж ахуйн нэгжүүдэд 21 нас хүрээгүй хүнд утаат болон электрон тамхи, түүний дагалдах хэрэгслийг худалдаалах, 21 нас хүрээгүй хүнээр тамхи худалдан борлуулахыг хориглосугай.

2.Тамхины хэрэглээ, никотины дасал, тамхинд нэрвэгдэхийн хор уршгийг таниулах, зөв дадалд уриалахад чиглэсэн мэдээлэл, сурталчилгааг тогтмол зохион байгуулахыг Эрүүл мэндийн газар (Г.Лхагважаргал), Боловсрол, шинжлэх ухааны газар (Ж.Амгаланбаатар), ерөнхий боловсролын сургуулийн захирлуудад үүрэг болгосугай.

3.Холбогдох хууль тогтоомж болон энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (Б.Золжаргал), Цагдаагийн газар (Н.Мэндбаяр), сумдын Засаг дарга нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

О.АМГАЛАНБААТАР